БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Г.БАТЗОРИГ

# АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2024 оны 05 сарын 13 өдөр | Дугаар: 2024/00-003 | Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ, үндэслэл | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/1415 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Балх-2 /14051/ бүсчлэлд хорооны байрны зүүн хойд талд "Аж, ахуйн" зориулалтаар эзэмшүүлсэн 1461909185 нэгж талбарын дугаартай 1.4584 га газрыг үндэслэв. |
| 2 | Барилга байгууламжийн нэр, зориулалт | **"Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ**<br>Авто зогсоол, засварын барилга |
| 3 | Барилгажих талбайн хэмжээ, хүчин чадал (Барилга бүрхэцийн харьцаа) | 7292.0 м² талбайд багтаана;<br>Барилгын бүрхцийн харьцааны 0.5 үзүүлэлтийг баримтлан 50%- аас дээшгүй талбайд барилгажуулна;<br>Тагт, консоль, довжоо болон рампыг эдэлбэр газарт, төлөвлөлтийн хязгаарт багтаан нормоор тооцон төлөвлөнө, (BCR). |
| 4 | Барилгын төрөл, давхрын тоо (Давхар талбайн харьцаа) | Тухайлсан зураг төсөлтэй (зоорьтой)<br>Давхар талбайн харьцааны 2.5 үзүүлэлтийг баримтлан 36460.0 м²-аас хэтрүүлэхгүй төлөвлөнө. (FAR) |
| 5 | Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл | "Бэлхийн цуурайт" зуслангийн ерөнхий төлөвлөгөө, Суурьшлын бүс |
| 6 | Эдэлбэр газрын: | 14584.0 м² |
| | – Барилгажих талбай | 7292.0 м² (ХБТХууль 12.8) |
| | – Ногоон байгууламж, гадна тохижилт төлөвлөх талбай | Эдэлбэр газрын 20%-аас доошгүй талбай (ХБТХууль 12.6.3) |
| | – Тоглоомын талбай, амрах талбай | БНбД 30-01-04-н 2 дугаар хүснэгтэд зааснаар (ХБТХууль 12.6.3) |
| | – Авто зогсоол | БНбД 31-01-10-н 13 дугаар хүснэгтэд зааснаар,<br>БНбД 30-01-04-н заавал мөрдөх 14 дүгээр хавсралтад зааснаар (ХБТХууль 12.6.3), Эдэлбэр газарт багтаан газар доорх зогсоол төлөвлөх боломжтой.<br>- Цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэгийг нийт зогсоолын хүчин чадлаас хамааруулан 3%-д төлөвлөнө.<br>- Унадаг дугуйн зам, зогсоол төлөвлөх,<br>- Авто замын төлөвлөлтийг орчны байдал, төлөвлөлттэй уялдуулан хорооллын авто замтай холбох, орц гарцыг нэгтгэн төлөвлөх. |
| 7 | Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага | - "Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах буулгах журам"-ын 4.1-т зааснаар төлөвлөн загвар зураг хийц, загварыг тусгах,<br>- Гудамж замын улаан шугам, талбайн тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж, явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүйгээр онцгой нөхцөлд ашиглах орц гарц төлөвлөх,<br>- хяналтын камер төлөвлөх, зөвшөөрөлгүй хашаа барихгүй байх;<br>- Зөвшөөрөлгүй хашаа барихгүй байх, барилгын түр хашааны өндөр 3 метр, хамгаалалтын торны өндөр 2 метр байна.<br>- Орчинтой уялдуулж ногоон байгууламж болон авто зогсоол талбайн тохижилтын зургийг иж бүрэн боловсруулна. |

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2024 оны 05 сарын 13 өдөр
СБТ 24956 2117401

| | | |
|---|---|---|
| 8 | Архитектур төлөвлөлтийн шаардлага | - Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх,<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт (MNS 6056:2009; 6055:2009) болон норм дүрэм (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм БД 31-112-11)-н дагуу төлөвлөх, барилгын зураг төсөлд хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргах,<br>- Төлөвлөж буй барилга орчмын гудамж замын зэрэглэлд тавигдах шаардлага, стандарттай нийцүүлэн барилгын гадна фасадыг цаг уурын онцлог /эрс тэс уур амьсгалтай хот/-т тохируулж барилгын чанар стандартад нийцсэн ачаалал даахуйц материал ашиглах, загвар зурагт өнгөний код, материалыг тодорхой тусгах, барилгын гадна фасадад барилгын дулаалгын хөөс, бусад шаардлага хангахгүй материал ашиглахгүй байх,<br>- Барилгын хаяг рекламыг фасадын зурагт тодорхой тусгаж орц орчимд захиалагч, зураг төсөл зохиогч, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн мэдээлэл бүхий мэдээллийг хүний харааны түвшинд байршуулж загвар зурагт зөвшилцөх,<br>- Барилгын суурийг эдэлбэр газарт багтаах, одоо байгаа болон төлөвлөгдсөн барилгуудын гал тэсвэршилтийн зэргийг тооцож тохиромжтой хийцийг сонгон төлөвлөнө. |
| 9 | Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл | - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто зам болон явган зам талбай, ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт хийх, барилгын фасадыг орчны барилгуудтай уялдуулан дэлгэмэл зургаар харуулах,<br>- Барилгын дээвэр, ханын элементэд шинэ дэвшилтэт технологи ашиглах, төлөвлөж буй барилгын эрчим хүчний хэрэглээний 10-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүч ашиглах технологийн шийдлийг тусгах,<br>- Барилгын дээвэр, ханын элементэд шинэ дэвшилтэт технологи ашиглах, барилга байгууламж нь өөрийн нөөц эх үүсгүүр, сэргээгдэх эрчим боломжтой төлөвлөх, барилгын гадна фасад, талбайн гэрэлтүүлгийг цогцоор төлөвлөх,<br>- Үндэсний уламжлалт хэв маягийг төлөвлөлтийн шийдэлд шингээсэн байх,<br>- Орчны барилгуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг судалж "Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм" БНбД 22-04-16-г баримтлан төлөвлөх, галын машин чөлөөтэй зорчих боломжийг гаргах,<br>- Галын аюулаас хамгаалах шаардлагыг мөрдөх, гал илрүүлэх болон унтраах зориулалттай автомат систем төлөвлөх, одоо байгаа барилгын гал тэсвэршилт болон хийцлэлийн дүгнэлтийг үндэслэн төлөвлөж буй барилгад тохиромжтой хийцийг сонгон төлөвлөх,<br>- Инженерийн шугам сүлжээг хамгаалах, хүчитгэх арга хэмжээг зураг төсөлд тусгах,<br>- Барилгын хаяг дугаар, гадна зар сурталчилгааны байгууламжийн харьцаа болон байгууллагын гудамжны дэлгэмэл зураг, нүүр тал, хажуу талуудын зураглал дээр тусгах,<br>- Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байна. |
| 10 | Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага | - Улаанбаатар хотын нэгдсэн өндөржилтийн төлөвлөлт болон нэгж хорооллын авто замын улаан шугам, өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөлтийн талбайд нэгдсэн өндөржилт төлөвлөлт хийх. |
| 11 | Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага | - Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан төлөвлөж, хамгаалалтын дэглэмийг мөрдөн ажиллах<br>- Инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийг эдэлбэр газарт багтаан, хамгаалалтын дэглэмийн дагуу |

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2024 оны 05-р сарын 13 өдөр
СБТ 24956 2117401

| | | |
|---|---|---|
| | | зай хэмжээг тооцон, хөрш залгаа эдэлбэр газарт нөлөөлөхгүйгээр төлөвлөн эх загвар зурагт тусгах.<br>- одоо байгаа шугам сүлжээний хэвийн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийхэд саадгүй байхаар төлөвлөх |
| 12 | Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ) | - Барилга байгууламжийг төлөвлөхдөө тухайн газрын гадаргууд өндөржилтийн хэмжилт хийх, үер, хөрсний нуралтаас хамгаалах бэхэлгээ, далан, суваг, гүүр, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг тусгах,<br>- эдэлбэр газарт байр зүйн зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах,<br>- барилгажих талбайд инженерийн шугам сүлжээ таарсан тохиолдолд холбогдох газартай зөвшилцөж, шилжүүлэх боломжтой эсэхийг тодруулсны дараа загвар зураг төслийг боловсруулах бөгөөд өөрийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.<br>- Газрын доорх болон гадаргуугийн ус ашиглах, зайлуулах арга хэмжээг орчны төлөв байдалтай уялдуулан талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх,<br>- Газрын ±0.00 төвшнөөс доош төлөвлөж буй байгууламжид гадаргын ус орохоос сэргийлж, ус зайлуулах систем төлөвлөх |
| 13 | Барилгажилтын улаан шугам | Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын тэг тэнхлэг тавиулж, барилгын ажлыг эхлүүлнэ. |
| 14 | Захиалагчийн нэр, албан тушаал, утас | "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ,<br>Утас: 976– 95956445 |

**Анхааруулга:**

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
3. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг хувийн хэрэгт хавсаргах.
4. Төлөвлөлтийн хязгаар нь барилга байгууламжийн гадна хийцийг хэтрүүлж болохгүй хил бөгөөд тоон утга (м, м$^2$, м$^3$)-аар илэрхийлэгдэхгүй болно.
5. Архитектур төлөвлөлтийн даалгавар нь Барилгын тухай хуулийн 35.1.3-т заасны дагуу барилга байгууламжийн байршлыг тодорхойлж буй баримт бичиг бөгөөд Зураг төсөл зохиогчоос архитектурын онцгой шийдэл, дэвшилтэт технологи, төлөвлөлтийн санал, санаачилга бүхий загвар зургийг ирүүлсэн тохиолдолд хянан батлах боломжтой зөвлөмж захиргааны акт юм. Барилгын тухай хуулийн 4.1.41-д заасан үе шатны ажлуудад батлагдсан загвар зургийг үндэслэнэ.
6. Шаардлагатай тохиолдолд нарны ээвэрлэлтийг орчны барилга байгууламжийн хамгийн их нөлөөлөлд өртөх хэсэгт норм хангаж байгааг нарийвчлан дүгнэлт гаргах бөгөөд хийсэн аргачлалаа файлаар өгч зөвшилцөнө. Мөн төлөвлөж буй барилгын 3 хэмжээст файл болон Ерөнхий төлөвлөгөөний файлыг загвар зураг батлах үед хот байгуулалтын менежментийн нэгдсэн сангийн жижүүрлэлтийг баяжуулах үүднээс хүлээлгэн өгнө.
7. "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2020, UCS 0902B:2020, UCS 1603C:2020, UCS 1601B:2020, UCS 1601C:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 0001-02:2019, UCS 1602B:2020, UCS 1602C:2020, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, UCS 1404C:2020-г тус тус мөрдөх.
8. Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсанаас хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд загвар зураг батлагдсанаар цаашид загвар зургийн хүчинтэй хугацаанд барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.
9. Газрын эрх цуцлагдсан болон хугацаа сунгагдаагүй тохиолдолд энэ актыг хүчингүйд тооцно.

ХЯНАСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАЛАНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ӨСӨХБАТ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2024 оны 05-р сарын 13 өдөр
СБТ 24955 2117401

# ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЯЗГААРЫН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: 2024/00-003 архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

| Байршил | Эзэмшигч | Зориулалт |
|---|---|---|
| Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо | "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ | Авто зогсоол, засварын барилга |




*Тусгаа: EPSG:32468*

*Масштаб 1:5000*

*(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)*

**ТАНИХ ТЭМДЭГ**

- Одоо байгаа барилга
- Төлөвлөлтийн хязгаарын хэмжээ
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

**ТОДОРХОЙЛОЛТ**

| | |
|---|---|
| 1 | *Төлөвлөж буй байршил* |
| 2 | *Одоо байгаа барилга* |
| 3 | *Цэцэрлэгийн барилга* |
| 4 | *Авто зам* |
| 5 | *Төлөвлөлтийн авто зам* |

**ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ**

| | |
|---|---|
| Эдэлбэр газар ( $м^2$ ) | 14584.0 |
| Барилгажих талбай ( $м^2$ ) | 7292.0 |

Эргэлтийн цэгүүдийн солбицол

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

*(Хавсралтад оруулав.)*

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

2024 оны 05-р сарын 13 өдөр

СБТ 24956 2117401


Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
Барилга, хот байгуулалтын хэлтэс

Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын ам /17100/,
Наадамчдын зам 1200
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn,
www.ebarilga.ub.gov.mn
Утас: 11-72707700

**АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН**
**ДААЛГАВРЫН СХЕМ ЗУРГИЙН ХАВСРАЛТ**
**(ДУГААР: 2024/00-003)**

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

| № | X | Y | тал=урт(m) |
|---|---|---|---|
| 1 | 648379.864 | 5320065.196 | 1-2=10.155 |
| 2 | 648387.871 | 5320058.950 | 2-3=21.267 |
| 3 | 648400.897 | 5320075.761 | 3-4=31.149 |
| 4 | 648425.494 | 5320056.650 | 4-5=21.288 |
| 5 | 648412.455 | 5320039.822 | 5-6=4.000 |
| 6 | 648415.614 | 5320037.368 | 6-7=41.673 |
| 7 | 648390.047 | 5320004.460 | 7-8=17.961 |
| 8 | 648403.307 | 5319992.345 | 8-9=88.836 |
| 9 | 648463.228 | 5320057.929 | 9-10=94.965 |
| 10 | 648387.671 | 5320115.457 | 10-11=102.187 |
| 11 | 648318.814 | 5320039.954 | 11-12=94.526 |
| 12 | 648390.313 | 5319978.124 | 12-13=18.937 |
| 13 | 648403.087 | 5319992.104 | 13-14=17.935 |
| 14 | 648389.846 | 5320004.202 | 14-15=45.310 |
| 15 | 648354.541 | 5320032.602 | 15-1=41.275 |

БАЙГУУЛАЛТ, ХОТЫН
СТАНДАРТЫН ГАЗАР

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2024 оны 05 -р сарын 13 өдөр
СБТ 24956 2117401

**Барилга барих хэсгийн тэмдэглэгээ**



БАТЛАВ:
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ГОМБОДОРЖ

# АВТО ЗОГСООЛ, ЗАСВАРЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 07 дугаар сарын 24-ны өдөр №1 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>- Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай 11/67 дугаар тогтоол<br>- Нийслэлийн Ерөнхий Архитекторын 2024.05.13-ны 2024/00-003 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар |
| 2. | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, 1461909185 нэгж талбарын дугаартай, 1.4 га газар |
| 3. | Зориулалт, хүчин чадал | - Авто зогсоол, засварын барилга |
| 4. | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно |
| 5. | Барилгын үндсэн бүтээц, материал | - Төслөөр |
| 6. | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | - Эх загвар зурагт үндэслэн ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах. |
| 7. | Зураг төслийн иж бүрдэл | Баримт бичгийн иж бүрдэл:<br>- Инженер геологийн дүгнэлт;<br>- Байр зүйн дэвсгэр зураг /газар доорх болон дээрх шугам сүлжээний тодруулгын хамт/;<br>- Батлагдсан загвар зураг:<br>- Онцгой байдлын дүгнэлт;<br>- Эрүүл ахуйн дүгнэлт<br>- Магадлалын дүгнэлт /хавсралтын хамт/;<br>Ажлын зургийн иж бүрдэл:<br>- Нүүр хуудас /батлагдсан/;<br>- ЕТ- Ерөнхий төлөвлөгөө;<br>- БА- Барилга архитектур;<br>- ТХ-Технологийн зураглал;<br>- ББ- Барилга бүтээц;<br>- ХС- Халаалт, агаар салхивч;<br>- ЦБУ- Усан хангамж, ариутгах татуурга;<br>- ХТ, ДГ- Хүчит тохеөрөмж, дотор гэрэлтүүлэг;<br>- ХД- Холбоо дохиолол;<br>- ГД- Гадна дулаан;<br>- УХАТ- Гадна усан хангамж, ариутгах татуурга; |

| | | |
|---|---|---|
| | | - ГЦ – Гадна цахилгаан;<br>- ГХ – Гадна холбоо;<br>- Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/;<br><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u><br>- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;<br>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:<br>  o Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх;<br>  o Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх; |
| 8. | Төсөл боловсруулах үе шат | Ажлын зураг төсөв хоёр үе шаттай:<br>- Эх загвар зураг боловсруулж, батлуулах;<br>- Ажлын зураг, төсөв боловсруулж, зөвшилцөж, батлуулах; |
| 9. | Төсөл боловсруулах байгууллага | - Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд; |
| 10. | Төслийн захиалагч | - Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ; |
| 11. | Онцгой нөхцөл | - Одоо байгаа засварын барилгатай холбох;<br>- Одоо байгаа барилгатай холболт хийхдээ барилгын бүтээцэд нөлөөлөхөөргүй тооцох;<br>- Шинээр зураг төсвийг боловсруулахаар тооцно.<br>- Ажлын зурагт үндэслэн ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна, тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах.<br>- Санал болгох үнийн дүнд шинээр хийгдэх зургийн үнэ, мөн гадна инженерийн шугам сүлжээний болон барилга угсралтын ажлын өртөг бүгд багтсан байна.<br>- Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх;<br>- Борооны ус зайлуулах байгууламжийг өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх<br>- Инженерийн шугам, сүлжээ нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт, зөөж шилжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг зураг, төсөвт тусгах;<br>- Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй түргэн аврагдах нөхцөлийг бүрдүүлэх;<br>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төсвийг боловсруулах; |

| | | |
|---|---|---|
| 12. | Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага. | Ерөнхий төлөвлөгөө:<br>- Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах;<br>- Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх;<br>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх<br>- Барилга байгууламжийн орц, гарцыг төв авто замын хөдөлгөөн, явган зорчигчийн хөдөлгөөн давхцахгүй байхаар нягт уялдуулан төлөвлөх;<br>- Ерөнхий төлөвлөгөөний элементийг цэцэрлэгийн барилгатай уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байхаар төлөвлөх; /Барилгын гадна байх зарлалын самбар, гадна гэрэлтүүлэг, мод, зүг чиг/<br>- Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр төлөвлөх ногоон байгууламжийг төлөвлөлтийн бүсээс гадна нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулан төлөвлөх боломжийг судлан зурагт тусгах;<br>Барилга:<br>- Өрөөний зохион байгуулалтыг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-тай зөвшилцөх;<br>- Барилгын онцлогийг архитектур орон зайн өвөрмөц шийдэлтэй байхаар тусгах;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөх<br>Инженерийн шугам сүлжээ:<br>- Инженерийн шугам сүлжээний тодруулгаар газар доор шугам сүлжээ илэрвэл зөөх шилжүүлэх ажлын зураг болон зардлыг тооцох<br>- Инженерийн шугам, сүлжээний техникийн нөхцөлийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт болон нөхөн сэргээлтийн ажлыг төсөвт тусгах<br>- Нөөц цахилгааны эх үүсвэртэй байх /Дизель генератор/<br>- Гадна болон анги дотор хяналтын камер төлөвлөх, Аудио систем төлөвлөсөн байх<br>- Тус барилгад розетка /ХТ/ төлөвлөхдөө норм стандартыг мөрдөж байршуулсан байх.<br>- Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт төлөвлөх<br>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангахуйц төлөвлөх.<br>- Бүлгийн өрөө тус бүрд хаалганы дээр цэнэг хураагууртай ослын гэрэлтүүлэгтэй байх. |
| 13. | Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | Төсөл, хөтөлбөрүүд:<br>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;<br>Хууль тогтоомжууд:<br>- Газрын тухай хууль;<br>- Барилгын тухай хууль;<br>Норм, нормативууд:<br>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04<br>- Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм БД 31-101-04<br>- Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж /БНбД II-66-88/ |

| | | |
|---|---|---|
| | | - Барилгын инженер геологийн ажил /БНбД 11-03-01/<br>- Барилгын геодезийн ажил /БНбД 11-08-06/<br>- Барилга захиалагчийн дүрэм<br>- Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНбД 20-01-11/<br>- Ачаалал ба үйлчлэл /БНбД 20-04-17/<br>- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02<br>- Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/<br>- Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНбД 22-01-01*/<br>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНбД 23-01-09/<br>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНбД 23-02-08/<br>- Барилгын дулаан хамгаалалт /БНбД 23-02-09/<br>- Дуу чимээ тусгаарлалт /БНбД 23-05-10/<br>- Олон нийт иргэний барилга /БНбД 31.03.03/<br>- Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-01-14/<br>- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-02-06/<br>- Барилга доторхи усан хангамж, ариутгах татуурга /БНбД 40-05-98/05*/<br>- Дотор сантехникийн ажил /БНбД 3.05.01-88/<br>- Усан хангамж, бохир ус, гадна шугам, түүний барилга байгууламж /БНбД 3.05.04-90/<br>- Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНбД 41-01-11/<br>- Дулааны сүлжээ /БНбД 41-02-13/<br>- Дулааны шугам сүлжээ /БНбД 3.05.03-95/<br>- Цахилгаан техникийн ажил /БНбД 3.05.06-90/<br>- Автомажуулалтын систем /БНбД 3.05.07-90/<br>- Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам /БНбД 52-01-10/<br>- Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм /БНбД 81-10-02/<br>- Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНбД 81-94-12/<br>- Барилгын төсөв зохион дүрэм /БНбД 81-95-12/<br>- Цахилгаан техникийн ажил /БНбД3.05.06-90/;<br>- Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНбД 32-01-04/<br>- Барилгын орчны тохижилтын ажил /БНбД 3.01-06-90/<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм<br>Стандартууд:<br>- "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000<br>- "Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ" MNS 12.013-91<br>- "Ажлын байрны хүчдэлийн түвшин" MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/;<br>- UCS0002-02:2019 Хүүхдийн тоглоомын талбай эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага |

| | | |
|---|---|---|
| | | - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS6056:2009<br>- Бусад холбогдох стандартууд |
| 14. | Галын аюулгүй байдлын нөхцөл | Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.01.02/, /БНбД 21.02.02/ |
| 15. | Эдийн засгийн тооцоо, төсөв | Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох. |

ХЯНАСАН:
БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ........................ /Б.Бат-Эрдэнэ/